455	Эмэгтэйчүүдийн үзлэгийн ор	2000/04/01	1	3,070,053.90	3,070,053.90	2	1,535,026.95	1,535,026.95
456	Эмэгтэйчүүдийн үзлэгийн ор	2000/04/01	2	3,070,053.90	6,140,107.80	2	1,535,026.95	3,070,053.90
457	Урологийн үзлэгийн ор	2000/04/01	1	3,086,334.90	3,086,334.90	2	1,543,167.45	1,543,167.45
458	Урологийн үзлэгийн ор	2000/04/01	1	3,086,334.90	3,086,334.90	2	1,543,167.45	1,543,167.45
459	Хамгаалалтын дэлгэц	2000/04/01	1	1,781,684.10	1,781,684.10	5	890,842.05	890,842.05
460	Хамгаалалтын дэлгэц	2000/04/01	1	1,781,684.10	1,781,684.10	5	890,842.05	890,842.05
461	Рентген хальсны шүүгээ	2000/04/01	1	736,624.80	736,624.80	5	368,312.40	368,312.40
462	Өндөр даралттай хүйтэн усаар цэвэрлэх хэрэгсэл	2018/09/20	1	4,752,000.00	4,752,000.00	5	2,376,000.00	2,376,000.00
463	Шүршэгч буу хий хоолойн хамт	2018/09/20	1	1,067,000.00	1,067,000.00	5	533,500.00	533,500.00
464	Нярайн үзлэгийн ширээ	2000/04/01	3	489,800.00	1,469,400.00	5	244,900.00	734,700.00
465	Доод мөчний үе сайжруулагч	1980/12/31	1	168,598.80	168,598.80	5	84,299.40	84,299.40
466	Хөлний үе сайжруулагч	2000/04/01	1	1,395,462.60	1,395,462.60	5	697,731.30	697,731.30
467	Дасгалын ор	2000/04/01	1	555,001.20	555,001.20	5	277,500.60	277,500.60
468	Үзлэгийн хаалт	2000/04/01	2	55,600.00	111,200.00	2	27,800.00	55,600.00
469	Үзлэгийн хаалт	2000/04/01	1	55,600.00	55,600.00	2	27,800.00	27,800.00
470	Үзлэгийн хаалт	2000/04/01	2	55,600.00	111,200.00	2	27,800.00	55,600.00
471	Үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
472	Үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
473	Үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
474	Үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
475	өндөр хэмжигч	2000/04/01	1	113,000.00	113,000.00	2	56,500.00	56,500.00
476	өндөр хэмжигч	2000/04/01	1	113,000.00	113,000.00	2	56,500.00	56,500.00
477	өндөр хэмжигч	2000/04/01	1	233,200.00	233,200.00	2	116,600.00	116,600.00

№	Хөрөнгийн нэрс	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж балансын үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох хугацаа (жил)	Шинэчлэн нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
478	өндөр хэмжигч	2000/04/01	1	113,000.00	113,000.00	2	56,500.00	56,500.00
479	өндөр хэмжигч	2000/04/01	1	113,000.00	113,000.00	2	56,500.00	56,500.00
480	үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
481	үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
482	үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
483	үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
484	үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
485	үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
486	үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
487	үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
488	үзлэг шинжилгээний ор	2000/04/01	1	98,700.00	98,700.00	5	49,350.00	49,350.00
489	үзлэгийн хаалт	2000/04/01	1	55,600	55,600.00	2	27,800.00	27,800.00
490	үзлэгийн хаалт	2000/04/01	1	55,600	55,600.00	2	27,800.00	27,800.00
491	үзлэгийн хаалт	2000/04/01	1	55,600	55,600.00	2	27,800.00	27,800.00
492	үзлэгийн хаалт	2000/04/01	1	55,600	55,600.00	2	27,800.00	27,800.00
493	багажны ширээ	2000/04/01	1	131,000	131,000.00	5	65,500.00	65,500.00
494	багажны ширээ	2000/04/01	1	131,000	131,000.00	5	65,500.00	65,500.00
495	биксний тавиур	2000/04/01	2	152,500	305,000.00	5	76,250.00	152,500.00
496	биксний тавиур	2000/04/01	2	152,500	305,000.00	5	76,250.00	152,500.00
497	дусал хийх хөдөлгөөнгүй тохойвч	2000/04/01	1	19,700	19,700.00	5	9,850.00	9,850.00
498	Саажилттай өвчтөний ор	2007/04/01	3	244,200	732,600.00	5	122,100.00	366,300.00
499	Нярай хүүхдийн жин хэмжигч	2011/12/19	1	1,943,600	1,943,600.00	5	971,800.00	971,800.00
500	Өвчтөн зөөх тэргэнцэр	2014/10/03	1	890,000	890,000.00	3	445,000.00	445,000.00
501	Өвчтөн зөөх тэргэнцэр	2014/10/03	1	890,000	890,000.00	3	445,000.00	445,000.00
502	Өвчтөн зөөх тэргэнцэр	2014/10/03	1	890,000	890,000.00	3	445,000.00	445,000.00
503	Амьсгалын аппарат-Heyer iTernis Base	2015/10/30	3	25,164,163.67	75,492,491.01	2	12,582,081.84	37,746,245.51
504	Агаарын компрессор eKom DK50 DE -Heyer iTernis Base амьсгалын аппарат	2015/10/30	3	16,000,000	48,000,000.00	2	8,000,000.00	24,000,000.00
505	Чийгшүүлэгч Heyer VH-1500 - Heyer iTernis Base амьсгалын аппарат	2015/10/30	3	2,149,800	6,449,400.00	2	1,074,900.00	3,224,700.00
506	Унтуулагын аппарат-Heyer Pasithec	2015/10/30	3	55,263,313.33	165,789,939.99	2	27,631,656.67	82,894,970.00
507	Ууршуулагч Dragger- Heyer Pasithec утлагын аппаратны	2015/10/30	6	4,800,000	28,800,000.00	2	2,400,000.00	14,400,000.00
508	Дижитал ЭХО аппарат-Alpinion E-CUBE 9	2015/10/30	1	46,888,000	46,888,000.00	2	23,444,000.00	23,444,000.00
509	Хар цагаан принтер Sony UP-D898-Дижитал ЭХО аппаратны Alpinion E-CUBE9	2015/10/30	1	2,500,000	2,500,000.00	2	1,250,000.00	1,250,000.00
510	DVD бичигч-Дижитал ЭХО аппаратны Alpinion E-CUBE9	2015/10/30	1	450,000	450,000.00	2	225,000.00	225,000.00

№	Хөрөнгийн нэрс	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж балансын үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох хугацаа (жил)	Шинэчлэн нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
511	Тэжээл ариутгах автоклав- YXQ-LS-50SII	2016/02/26	1	3,700,000	3,700,000.00	2	1,850,000.00	1,850,000.00
512	Дуслын тариурын автомат шахуурга IP12B	2016/05/02	1	2,600,000	2,600,000.00	2	1,300,000.00	1,300,000.00
513	Дуслын тариурын автомат шахуурга IP12B	2016/05/02	1	2,600,000	2,600,000.00	2	1,300,000.00	1,300,000.00
514	Отсос MS 700L	2016/05/05	1	1,700,000	1,700,000.00	2	850,000.00	850,000.00
515	Сорох аппарат AS-200A	2016/05/30	1	647,020	647,020.00	2	323,510.00	323,510.00
516	Сорох аппарат AS-200A	2016/05/30	1	647,020	647,020.00	2	323,510.00	323,510.00
517	Сорох аппарат AS-200A	2016/05/30	1	480,000	480,000.00	2	240,000.00	240,000.00
518	Сорох аппарат AS-200A	2016/05/30	1	647,020	647,020.00	2	323,510.00	323,510.00
519	Сорох аппарат AS-200A	2016/05/30	1	647,020	647,020.00	2	323,510.00	323,510.00
520	Пейсмейкерийн хяналтын зөөврийн монитор	2016/06/30	1	19,704,500	19,704,500.00	2	9,852,250.00	9,852,250.00
521	Отсос	2016/07/21	1	4,500,000	4,500,000.00	2	2,250,000.00	2,250,000.00
522	Отсос	2016/07/21	1	4,500,000	4,500,000.00	2	2,250,000.00	2,250,000.00
523	Harmonic Endo-Surgery	2016/07/21	1	70,000,000	70,000,000.00	3	35,000,000.00	35,000,000.00
524	Биополяр-Caiman Aesculap	2016/07/21	1	50,000,000	50,000,000.00	3	25,000,000.00	25,000,000.00
525	Зөөврийн отсос-7E-A	2016/08/01	1	300,000	300,000.00		150,000.00	150,000.00
526	Бүлэгнэлтийн бүрэн автомат анализатор-CS-1600	2016/09/01	1	89,613,840	89,613,840.00	3	44,806,920.00	44,806,920.00
527	Паноптик офтальмоскопийн багц-97800 MC	2016/10/28	1	5,000,000	5,000,000.00	2	2,500,000.00	2,500,000.00
528	Паноптик офтальмоскопийн багц-97200 MPS	2016/10/28	1	5,000,000	5,000,000.00	2	2,500,000.00	2,500,000.00
529	Биеийн индекс тодорхойлогч Inbody 570	2016/12/28	1	24,895,300	24,895,300.00	2	12,447,650.00	12,447,650.00
530	Зүрхний цахилгаан бичлэг Bionet Cardio 7	2016/12/28	1	5,178,222	5,178,222.00	2	2,589,111.00	2,589,111.00
531	Цусны даралтын аппарат	2016/12/28	1	4,481,154	4,481,154.00	2	2,240,577.00	2,240,577.00
532	ДНХ/РНХ олшруулагч бүрэн автомат төхөөрөмж/ Dt Lite 4SI /	2017/05/10	1	45,000,000	45,000,000.00	2	22,500,000.00	22,500,000.00
533	Термостат 1,5 мкл	2017/05/10	1	3,000,000	3,000,000.00	2	1,500,000.00	1,500,000.00
534	Центрифуг CM-50	2017/05/10	1	4,500,000	4,500,000.00	2	2,250,000.00	2,250,000.00
535	Центрифуг CM-70	2017/05/10	2	3,200,000	6,400,000.00	2	1,600,000.00	3,200,000.00
536	Аспиратор -FTA	2017/05/10	1	2,200,000	2,200,000.00	2	1,100,000.00	1,100,000.00
537	Спирометрийн аппарат	2017/10/02	1	6,950,000	6,950,000.00	2	3,475,000.00	3,475,000.00
538	Тарианы памп /LINZ-9A/	2017/12/14	1	1,650,000	1,650,000.00	2	825,000.00	825,000.00
539	Тарианы памп /LINZ-9A/	2017/12/14	1	1,650,000	1,650,000.00	2	825,000.00	825,000.00
540	Тарианы памп /LINZ-9A/	2017/12/14	1	1,650,000	1,650,000.00	2	825,000.00	825,000.00
541	Тарианы памп /LINZ-9A/	2017/12/14	1	1,650,000	1,650,000.00	2	825,000.00	825,000.00
542	Өвчтөний хяналтын монитор/PM-9000GTA хятад/	2018/12/03	1	4,900,000	4,900,000.00	2	2,450,000.00	2,450,000.00
543	Өвчтөний хяналтын монитор/PM-9000GTA хятад/	2018/02/21	2	3,200,000	6,400,000.00	2	1,600,000.00	3,200,000.00
544	Коагуляцийн аппарат	2018/07/31	1	4,800,000	4,800,000.00	3	2,400,000.00	2,400,000.00
545	Холтер монитор /9293-036-52 / RevA1/	2018/09/28	4	3,361,644	13,446,576.00	2	1,680,822.00	6,723,288.00
546	HORUS SCOPE 100/Нүдний уг дурандах аппарат/	2018/10/10	1	12,584,000	12,584,000.00	2	6,292,000.00	6,292,000.00

№	Хөрөнгийн нэрс	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж балансын үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох хугацаа (жил)	Шинэчлэн нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
547	Сорох төхөөрөмж (II-002)	2018/12/03	1	400,000	400,000.00	2	200,000.00	200,000.00
548	Сорох төхөөрөмж (II-002)	2017/12/01	1	400,000	400,000.00	2	200,000.00	200,000.00
549	Сорох төхөөрөмж (II-002)	2017/12/01	1	400,000	400,000.00	2	200,000.00	200,000.00
550	Сорох төхөөрөмж (II-002)	2017/12/01	1	400,000	400,000.00	2	200,000.00	200,000.00
551	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч (LFY-1-E)	2017/12/01	1	2,000,000	2,000,000.00	2	1,000,000.00	1,000,000.00
552	Тарианы автомат шахуурга (ST-8800)	2017/12/01	1	1,780,000	1,780,000.00	2	890,000.00	890,000.00
553	Тарианы автомат шахуурга (ST-8800)	2017/12/01	1	1,250,000	1,250,000.00	2	625,000.00	625,000.00
554	Судас тодруулагч /Astodia/	2018/12/03	1	2,310,000	2,310,000.00	2	1,155,000.00	1,155,000.00
555	Амьсгал хэмжигч /CNNAN BMC-730/	2018/12/03	1	4,700,000	4,700,000.00	2	2,350,000.00	2,350,000.00
556	Хөлдөөгч -20хэмтэй	2019/04/10	1	19,454,539.10	19,454,539.10	2	9,727,269.55	9,727,269.55
557	Лабораторийн хөргөгч	2019/04/10	2	7,435,211.78	14,870,423.56	2	3,717,605.89	7,435,211.78
558	Автоклав 60л /дунд/	2019/04/10	1	15,177,894.73	15,177,894.73	2	7,588,947.37	7,588,947.37
559	Автоклав 100л /Том/	2019/04/10	1	22,389,491.12	22,389,491.12	2	11,194,745.56	11,194,745.56
560	Хэт авиан угаах төхөөрөмж/ Ultrasonic 57 L /	2019/04/04	1	23,576,960.72	23,576,960.72	2	11,788,480.36	11,788,480.36
561	Угаагч ба халдваргүйжүүлэх төхөөрөмж 2 хаал/ Washer-decontaminator -310 L /	2019/04/04	2	159,030,500.86	318,061,001.72	2	79,515,250.43	159,030,500.86
562	Өндөр даралттай уураар ариутгагч аппарат 600L /2хаалга/ / MSG.B /	2019/05/23	2	150,980,346.27	301,960,692.54	2	75,490,173.14	150,980,346.27
563	Плазм ариутгалын төхөөрөмж 140L / MD-J.T/ бага температурт/	2019/05/23	1	94,106,990.90	94,106,990.90	2	47,053,495.45	47,053,495.45
564	Нянг ялган дүйх болон антибиотик мэдрэг чанар тодорхойлох автомат систем	2019/06/07	1	174,899,181.60	174,899,181.60	2	87,449,590.80	87,449,590.80
565	Цусны өсгөвөрийн шинжилгээний автомат систем	2019/06/07	1	55,105,221.60	55,105,221.60	2	27,552,610.80	27,552,610.80
566	Зөөврийн рентген аппарат C ARM ZEN-2090Pro	2019/07/23	1	194,000,000.00	194,000,000.00	2	97,000,000.00	97,000,000.00
567	Тарилгын автомат шахуурга	2022/01/01	1	2,628,446.00	2,628,446.00	2	1,314,223.00	1,314,223.00
568	Тарилгын автомат шахуурга	2022/01/01	4	2,628,446.00	10,513,784.00	2	1,314,223.00	5,256,892.00
569	Яаралтай тусламж болон эрчимт эмчилгээний багажны иж бүрдэл	2022/01/01	1	10,513,782.00	10,513,782.00	2	5,256,891.00	5,256,891.00
570	Нуруу хүзүүний татлагын ор	2022/12/30	1	5,975,500.00	5,975,500.00	2	2,987,750.00	2,987,750.00
571	УВЧ шарлагын аппарат	2022/12/30	1	732,600.00	732,600.00	2	366,300.00	366,300.00
572	Химийн бодисын хог хаягдал хадгалах шүүгээ/SSM 100045/	2018/09/10	1	2,090,000.00	2,090,000.00	2	1,045,000.00	1,045,000.00
573	Хүчилтөрөгчийн хийн инсуффлятор/UCR OLYMPUS N2654440/	2019/11/05	1	13,236,300.00	13,236,300.00	2	6,618,150.00	6,618,150.00
574	Усны памп/OFP-2/ OLYMPUS	2019/11/05	1	8,034,400.00	8,034,400.00	2	4,017,200.00	4,017,200.00
575	Ходоодны хэт нарийн дуран/GIF XP190N OLYMPUS/	2019/11/05	1	56,540,000.00	56,540,000.00	2	28,270,000.00	28,270,000.00
576	Цус тогтоох хавчаарны гар 2,8мм/HX-110UR OLYMPUS/	2019/11/05	5	1,298,000	6,490,000.00	2	649,000.00	3,245,000.00

№	Хөрөнгийн нэрс	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж балансын үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох хугацаа (жил)	Шинэчлэн нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
577	Цус тогтоох хавчаарны гар 3,2мм/HX-110LR OLYMPUS/	2019/11/05	5	1,298,000	6,490,000.00	2	649,000.00	3,245,000.00
578	Гистероскопийн оптик/11264BBK1-KARL STORZ/	2019/11/05	1	40,860,600	40,860,600.00	2	20,430,300.00	20,430,300.00
579	Дурангийн хөрвүүлэгч/27005CA-KARL STORZ/	2019/11/05	1	13,119,700	13,119,700.00	2	6,559,850.00	6,559,850.00
580	Бага даралтын ариутгалын аппарат/автоклав/ Этилен ислээр ариутгах/HP-5012T/	2021/10/29	1	212,904,086	212,904,086.00	2	106,452,043.00	106,452,043.00
581	Микроскопи/2 нүдний/	2021/10/29	6	7,885,336.50	47,312,019.00	2	3,942,668.25	23,656,009.50
582	Дархан туяарах гэрлээр оношлох микроскопи	2021/10/29	1	89,367,147	89,367,147.00	2	44,683,573.50	44,683,573.50
583	Холигч/БНСУ Hwha shin 150RT /	2021/10/29	1	1,577,067	1,577,067.00	2	788,533.50	788,533.50
584	Холигч/цус холигч/БНСУ 205RM/	2021/10/29	3	1,051,378	3,154,134.00	2	525,689.00	1,577,067.00
585	Тавиуртай сорьц хатаагч	2021/10/29	1	7,885,336.58	7,885,336.58	2	3,942,668.29	3,942,668.29
586	Тавиуртай сорьц хатаагч	2021/10/29	6	7,885,336.57	47,312,019.42	2	3,942,668.29	23,656,009.71
587	Тарилгын автомат шахруурга	2021/10/29	26	2,628,445.50	68,339,583.00	2	1,314,222.75	34,169,791.50
588	Тарилгын автомат шахруурга	2021/10/29	2	2,628,445.50	5,256,891.00	2	1,314,222.75	2,628,445.50
589	Тарилгын автомат шахруурга	2021/10/29	7	2,628,445.50	18,399,118.50	2	1,314,222.75	9,199,559.25
590	Тарилгын автомат шахруурга	2021/10/29	1	2,628,445.50	2,628,445.50	2	1,314,222.75	1,314,222.75
591	Тарилгын автомат шахруурга	2021/10/29	1	2,628,445.50	2,628,445.50	2	1,314,222.75	1,314,222.75
592	Тарилгын автомат шахруурга	2021/10/29	1	2,628,445.50	2,628,445.50	2	1,314,222.75	1,314,222.75
593	Тарилгын автомат шахруурга	2021/10/29	2	2,628,445.50	5,256,891.00	2	1,314,222.75	2,628,445.50
594	Тарилгын автомат шахруурга	2021/10/29	3	2,628,445.50	7,885,336.50	2	1,314,222.75	3,942,668.25
595	Тарилгын автомат шахруурга	2021/10/29	5	2,628,445.50	13,142,227.50	2	1,314,222.75	6,571,113.75
596	Тарилгын автомат шахруурга	2021/10/29	2	2,628,445.50	5,256,891.00	2	1,314,222.75	2,628,445.50
597	Сийвэн гэсгээгч	2021/10/29	1	42,055,128	42,055,128.00	2	21,027,564.00	21,027,564.00
598	Усан банн +37	2021/10/29	1	1,839,912	1,839,912.00	2	919,956.00	919,956.00
599	Бактерийн хоруу чанар тодорхойлогч Endosafe PTS систем	2021/10/29	1	120,157,509	120,157,509.00	2	60,078,754.50	60,078,754.50
600	Молекул биологийн анализатор	2021/10/29	1	418,048,000	418,048,000.00	2	209,024,000.00	209,024,000.00
601	Шээсний тунадас уншигч автомат анализатор/U411/	2021/10/29	1	86,738,702	86,738,702.00	2	43,369,351.00	43,369,351.00
602	Автомат тариур/KARL 100/	2021/10/29	1	657,111,377	657,111,377.00	2	328,555,688.50	328,555,688.50
603	Бактерологийн ламинар бокс/GH-1200/	2021/10/29	1	23,656,010	23,656,010.00	2	11,828,005.00	11,828,005.00
604	Биохимийн бүрэн автомат анализатор/COBAS C501/	2021/10/29	1	541,459,775	541,459,775.00	2	270,729,887.50	270,729,887.50
605	Цусны эс тоологч// 312DF/	2021/10/29	1	1,314,223	1,314,223.00	2	657,111.50	657,111.50
606	Цусны эс тоологч камер/ Pentra XLR/	2021/10/29	1	118,905,868	118,905,868.00	2	59,452,934.00	59,452,934.00
607	Цусны хөргөгч/Humanlab BBO-245/	2021/10/29	1	21,027,564	21,027,564.00	2	10,513,782.00	10,513,782.00
608	Давхар ус нэрэгч /Milli-Q 7080/	2021/10/29	4	49,940,464.67	199,761,858.68	2	24,970,232.34	99,880,929.34
609	Давхар ус нэрэгч /Milli-Q 7080/	2021/10/29	1	49,940,464.65	49,940,464.65	2	24,970,232.33	24,970,232.33



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 316

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой, 13 нэрийн, нийт 36,288,863.31 (гучин зургаан сая хоёр зуун наян найман мянга найман зуун жаран гурван төгрөг гучин нэг мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 17,881,897.50 (арван долоон сая найман зуун наян нэгэн мянга найман зуун ерэн долоон төгрөг тавин мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирал Б.Бямбадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг ашиглах хугацаа, үнэ шинэчлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001158

15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2025 оны 9 дугаар сарын... ны/ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж балансын үнэ (үнэ)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)	Цаашид шинэчлэх нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
1	Note book /Dell/ I3	2019-12-30	2	2,240,915.00	4,481,830.00	3	1,100,000.00	2,200,000.00
2	Note book /Dell/ I3	2019-12-30	2	2,568,184.00	5,136,368.00	3	1,200,000.00	2,400,000.00
3	Серверийн компьютер /HUAWEI/	2015-12-23	1	19,344,970.31	19,344,970.31	3	9,600,000.00	9,600,000.00
4	Принтер /HP 102A/	2018-12-24	2	280,000.00	560,000.00	3	150,000.00	300,000.00
5	Рак /зүүн байр /	2018-06-04	1	1,101,900.00	1,101,900.00	4	550,000.00	550,000.00
6	Ажилтны сандал	2011-12-30	12	142,000.00	1,704,000.00	4	71,000.00	852,000.00
7	Хувцасны шүүгээ /шар/	2004-01-01	1	115,000.00	115,000.00	4	57,500.00	57,500.00
8	Бичгийн ширээ /жижиг/	2005-01-01	2	81,670.00	163,340.00	4	40,835.00	81,670.00
9	Бичгийн ширээ /том/	2005-01-01	5	107,731.00	538,655.00	4	53,865.50	269,327.50
10	Ширээ /модон/	2004-01-01	13	65,000.00	845,000.00	4	32,500.00	422,500.00
11	Ширээ /модон/	2011-12-30	7	250,000.00	1,750,000.00	4	125,000.00	875,000.00
12	Шүүгээ 841	2005-01-01	1	209,000.00	209,000.00	4	104,500.00	104,500.00
13	Шилтэй шкаф /хүрэн/	2009-09-18	1	338,800.00	338,800.00	4	169,400.00	169,400.00
НИЙТ ДҮН					36,288,863.31		13,254,600.50	17,881,897.50
					(гучин зургаан сая хоёр зуун наян найман мянга найман зуун жаран гурван төгрөг гучин нэг мөнгө)			(арван долоон сая найман зуун наян нэгэн мянга найман зуун ерэн долоон төгрөг тавин мөнгө)



УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/77.

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын
хугацаа сунгах, үнийг
шинэчлэн тогтоох

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.1, 14.2.1, 31.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.1, 14.4.1, 14.4.5, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 7.1, 7.3 дугаар зүйлийн 7.3.5 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 295, 316 дугаар тогтоолууд, Эмнэлгийн дотоод журмын 3.1.1 зүйл, Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн 2025 оны 06, 07 дугаар хуралдааны тэмдэглэлүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой, 641 нэрийн, нийт 13,201,735,916 (арван гурван тэрбум хоёр зуун нэгэн сая долоон зуун гучин таван мянга есөн зуун арван зургаан) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 6,597,042,917.80 (зургаан тэрбум таван зуун ерэн долоон сая дөчин хоёр мянга есөн зуун арван долоон төгрөг наян мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу санхүүгийн бүртгэлд тусгах ажлыг ахлах нягтлан бодогч (А.Гэрэлт-од)-д даалгасугай.
2. Байгууллагын дахин үнэлгээ хийх эмнэлгийн тоног төхөөрөмжийн жагсаалтыг нэгдүгээр, компьютер хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар, тавилга, эд хогшлын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэж биелэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт явуулахыг Санхүү, бүртгэлийн албаны даргын ажил үүргийг түр хавсран гүйцэтгэгч, Эдийн тасгийн албаны дарга (М.Солонго)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа хүний нөөцийн албаны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, зохион байгуулалт хариуцсан менежер (Б.Даваасүрэн)-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Э.АНХБАЯР



27251164

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн
Өмч хамгаалах байнгын зөвлөлийн
хурлын тэмдэглэл

2025 оны 07-р сарын 03-ны өдөр

Дугаар №06

Улаанбаатар хот

Хуралд өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга Ч.Энхболд, Гишүүд Ц.Батмандах, А.Гэрэлт-Од, Г.Батзаяа Ж.Нарантунгалаг, Г.Мөнхтулга, Т.Мөнхтогтох, Ц.Золжаргал, Ж.Дөл, Э.Алтансүх, нарийн бичгийн даргаар М.Оюунтунгалаг нарын бүрэлдэхүүнтэй 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 10.00 цагт Үндэсний оношлогооны төвийн 2 давхарын хурлын танхимд хуралдав. З.Арьяасүрэн, Э.Энхболд ээлжийн амралттай.

Хурлыг нээж Ч.Энхболд: Өнөөдрийн өмч хамгаалах хурлыг нээж байна.

Хэлэлцэх асуудлуудыг танилцуулав. Үүнд:

Хэлэлцэх асуудал:

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 295 дугаар тогтоолын талаар- Ж.Нарантунгалаг
2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 304 дүгээр тогтоолын талаар- Ж.Нарантунгалаг
3. Эмнэлгийн захирлын 2025 оны А/124 дүгээр тушаалын биелэлтийн талаар- М.Оюунтунгалаг
4. Өмч хамгаалах зөвлөлийн 2025 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийн талаар-М.Оюунтунгалаг
5. 50 ортын 1 давхарын дэлгүүрийн сул талбайг түрээслүүлэх талаар

Хэлэлцсэн нь:

Нэгдүгээр асуудал:

Ч.Энхболд: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 295 дугаар тогтоолын талаар нягтлан бодогч Ж.Нарантунгалаг танилцуулна гэв.

Ж.Нарантунгалаг: Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох тухай 2025 оны 06 дугаар сарын 27-ы өдрийн 295-р ТӨБЗГазрын тогтоолын дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой, 628 нэрийн, нийт 13,165,447,053 (арван гурван тэрбум нэг зуун жаран таван сая дөрвөн зуун дөчин долоон мянга тавин гурав) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 6,579,161,020.30 (зургаан тэрбум таван зуун далан есөн сая нэг зуун жаран нэгэн мянга хорин төгрөг гучин мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу санхүүгийн бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулж захирлын тушаал гаргана.

Ц.Батмандах: 2024 оны аудитын зөвлөмжийн дагуу эмнэлгийн захирлын 2025 оны А/83-р тушаалын дагуу ажлын хэсэг томилогдон ажлын хэсгийн ахлагчаар би өөрөө томилогдон үнэлгээг хийсэн. Үнэлгээг хийхдээ Эмнэлгийн тоног төхөөрөмж, Мэдээлэл технологийн албад болон хариуцсан няравуудаар тус бүр үнэлгээг нэг бүрчлэн хийж ажлын хэсэг хуралдан нэг бүрчлэн үнэлгээг хийсэн болно.

Ч.Энхболд: Тогтоолын дагуу эмнэлгийн захирлын тушаал гарган санхүүгийн бүртгэлд тусган хариуг хугацаанд нь явуулахыг ахлах нягтлан бодогч А.Гэрэлт-одод даалгаж байна.

Гишүүд санал нэгтгэйгээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 295-р тогтоолын дагуу эмнэлгийн захирлын тушаал гарган дахин үнэлгээг журмын дагуу хийхийг зөвшөөрөв.

Хоёрдугаар асуудал:

Ч.Энхболд: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 304 дүгээр тогтоолын талаар нягтлан бодогч Ж.Нарантунгалаг танилцуулна гэв.

Ж.Нарантунгалаг: Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай 2025 оны 304 дүгээр ТӨБЗГазрын тогтоолын дагуу тус эмнэлгийн үндсэн хөрөнгөд

бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, сэргээн засварлах боломжгүй болсон ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 45 нэрийн, нийт 368,980,320.19 төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгөнүүдийг акталж данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эмнэлгийн “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн хяналт дор зохион байгуулж, үр дүнг 2025 оны 08 дугаар сарын 15-ны биелэлтийг явуулна. Үүний дагуу ажлын хэсэг томилон эмнэлгийн захирлын тушаал гаргана. Эм эмнэлгийн хэрэгслийн газарт хүсэлт явуулан тоног төхөөрөмжийн техникийн дүгнэлтээ одоо байгаа үеийн байдлаар зурагжуулж шинэчлэн явуулж тогтоол гарсан.

М.Оюунтунгалаг: Манай эмнэлэг 2021 оноос хойш эмнэлгийн тоног төхөөрөмжийн акты зөвшөөрөл гараагүй. 2023 оны жилийн эцсийн тооллогын ажлын хэсгээс санал оруулсан дагуу 2024 онд Эрүүл мэндийн яаманд актлах саналаа явуулсан. Тухайн жил Эм эмнэлгийн хэрэгслийн газрын зөвшөөрөл байхгүй гэсэн шалтгаанаар асуудал шийдэгдээгүй. 2025 онд нягтлан бодогч Нарантунгалаг өөрийн биеэр маш сайн хөөцөлдсөний үр дүнд тогтоол гарсан.

Ц.Батмандах: Тогтоол акталж устган данснаас хассугай гэж гарсан тул актанд орсон хөрөнгийг няравын агуулахад цуглуулан хаяж устгах хэрэгтэй. Ажлын хэсэг энэ ажлыг журмын дагуу хийж гүйцэтгэх хэрэгтэй. Төрийн өмчийн гэрээний биелэлт дүгнэхээр ажлын хэсэг ирэхэд тогтоолын биелэлтийг газар дээр үзэж танилцдаг тул акталсан хөрөнгө эмнэлэгт байх ёсгүй.

Ч.Энхболд: Тогтоолын дагуу ажлын хэсэг томилон жагсаалтал орсон хөрөнгийг хаяж устгах шаардлагатай тул эмнэлгийн захирлын тушаал гаргах саналтай байна.

Гишүүд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 304 дүгээр тогтоолын дагуу ажлын хэсэг томилох эмнэлгийн захирлын тушаал гаргахаар санал нэгтэй зөвшөөрөв.

Гуравдугаар асуудал:

Ч.Энхболд: Эмнэлгийн захирлын 2025 оны А/124 дүгээр тушаалын биелэлтийн талаар нягтлан бодогч М.Оюунтунгалаг танилцуулна гэв.

М.Оюунтунгалаг: Эд хөрөнгийн дотоодын тооллого хийх тухай эмнэлгийн захирлын 2025 оны 05 сарын 23-ны А/124 тоот тушаал гарсан. Тушаалын дагуу ажлын хэсэг томилогдон тооллого явагдаж дууслаа. Аж ахуй үйлчилгээний албаны няравуудын хооронд тасаг сольсонтой холбоотой няравууд тооллогыг голчлон хийсэн. Ноднин эд хариуцагчийн картыг хэвлэж амжилгүй, программын үлдэгдлээр баримт бүрдүүлсэн. Аудит эд хариуцагчийн карт байх ёстой гэсэний дагуу энэ жил нягтлангууд программын тулгалттай эксел файлыг тааруулж зурагжуулан хэвлэж архивын баримт үүсгэсэн. Мөн тооллогын илтгэх хуудас гарсан уншиж танилцуулья. /Илтгэх хуудсыг хавсаргав./ илүүдэлтэй болон дутагдалтай хангамжийн бараа материал байхгүй. Актлах санал тооллогын комисоос оруулж ирсэн. Жагсаалтыг танилцуулж байна. Холбогдох тасаг албадын дарга нарт жагсаалтыг өгч нэгдсэн дүгнэлтийг гаргуулах хүсэлтэй байна. Мөн зөөлөн эдлэл цагаан хэрэгсэл, нормын хувцасны акты саналын жагсаалтыг дагуу 2023 оны 12 сар дуустал актлах саналтай байна. Ашиглалтын норм дууссан, зарим алба тасагт программд байгаа тооноос бага цагаан хэрэглэл байна. Мөн ажлаас гарсан ажигчдын хэрэглэж байсан халад, нормын хувцасыг актлах саналтай.

А.Гэрэлт-Од: Тооллого эхлэхэд ажлын хэсгийг ахлагч Цогт-Очир цуглуулан хуралдуулсан, үүн дээр тооллого хэрхэн явагдах талаар зөвлөмж миний зүгээс өгсөн. тооллого хугацаандаа хариуцлагатай явагдаж дууслаа. Өмнөх аудитаар хангамжийн материалын үлдэгдэл маш ихтэй байна гэсэн зөвлөмж гарсан. Үүний дагуу актлах хөрөнгийг сайтар нягталж үзэн захирлын тушаалын төсөл гаргах хэрэгтэй.

Ж.Нарантунгалаг: Эмнэлгийн жижиг хэрэгслийн жагсаалтыг Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албанд хүргүүлж актлах эсэхийг нягтлах нь зүйтэй болов уу. Тэгэхгүй бол зарим нэг бараа материалыг эд хариуцагч нар актлана гэсэн саналаа өгөөд эргэж ашиглах магадлалтай байдаг.

Ч.Энхболд: Тооллогын илтгэх хуудастай танилцлаа. Ажлын хэсгээс оруулж ирсэн актлах бараа материалын жагсаалтыг дахин холбогдох албадаар шалгуулан дараагийн хуралд оруулан эмнэлгийн захирлын тушаал гаргуулах саналтай байна.

Гишүүд санал нэгтэй тооллогын ажлын хэсгээс оруулж ирсэн актлах саналтай бараа материалын жагсаалтыг холбогдох алба, тасгууд хяналт тавьж дараагийн хуралд саналыг оруулж ирэхээр зөвшөөрөв.

Дөрөвдүгээр асуудал:

Ч.Энхболд: 2025 оны эхний хагас жилийн байдлаар эмнэлгийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөвлөгөөний биелэлтийг танилцуулна гэв.

М.Оюунтунгалаг: 2025 оны 1 дүгээр сарын 15-нд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөвлөгөөг захирлаар батлуулан биелэлтийг хангаж ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан асуудлууд эхний хагас жилийн байдлаар 100 хувь биелэсэн. /Биелэлтийг хавсаргав./

Ц.Батмандах: Зөвлөлийн гишүүдэд хуралд суусан байдлаар урамшуулал өгнө гэж журманд заагдсан байдаг. Энэ асуудал яригдаж байгаад чимээгүй болсон. Төлөвлөгөөнд орсон уу.

Ч.Энхболд: Байгууллагын нилээд хэдэн зөвлөл байгаа бүгд урамшуулал болон цалин авдаггүй тул нийтийн жишгээр урамшуулал олдохгүй байхаа.

Гишүүд Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлттэй танилцав.

Тавдугаар асуудал:

Ч.Энхболд: Манай эмнэлэг 2024 онд нийт 10 байгууллагатай түрээсийн гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байснаас "Бьюлдинг дизайн" ХХК-ний гэрээний хугацаа болон сунгалт дуусгавар болсон. Уг компанид мэдэгдэл явуулан эмнэлгийн талбайг чөлөөлүүлсэн. 50 орт байранд урсгал засвар хийхтэй холбогдуулан сонгон шалгаруулалтыг түр хойшлуулсан байсан боловч хөрөнгө мөнгөний асуудал шийдэгдэхгүй байгаа мөн ажилчдаас дэлгүүр ажиллуулах хүсэлт байнга ирж байгаа тул уг сул талбайг дэлгүүрийн зориулалтаар түрээслүүлэх сонгон шалгаруулалтыг зарлах хүсэлтэй байна.

А.Гэрэлт-Од: Шинээр дэлгүүрийн сонгон шалгаруулалт зарлахтай холбогдуулан талбайг ахин хэмжилт хийлгэх хэрэгтэй.

Гишүүд санал нэгтгэйгээр дэлгүүрийн сул талбайг түрээслүүлэх сонгон шалгаруулалтыг зарлахаар санал нэгтэй зөвшөөрөв.

Шийдвэрлэсэн нь:

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 295-р тогтоолын дагуу эмнэлгийн захирлын тушаал гарган дахин үнэлгээг журмын дагуу хийхийг нягтлан бодогч Ж.Нарантунгалагт
2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 304 дүгээр тогтоолын дагуу ажлын хэсэг томилох эмнэлгийн захирлын тушаал гаргахыг нягтлан бодогч Ж.Нарантунгалагт
3. Эмнэлгийн захирлын 2025 оны А/124-р тушаалын дагуу томилогдсон тооллогын ажлын хэсгээс оруулж ирсэн актлах саналтай бараа материалын жагсаалтыг холбогдох алба, тасгууд хяналт тавьж дараагийн хуралд саналыг оруулахыг нягтлан бодогч М.Оюунтунгалагт
4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 50 орт байрны 1 давхарт байрлах дэлгүүрийн сул талбайг түрээслүүлэх сонгон шалгаруулалтыг зарлахыг эдийн засагч Т.Нямсүрэн нарт тус тус даалгав.

Хурал 12 цагт тарав.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн
Дарга

Гишүүд:



Ч.Энхболд

Ц.Батмандах

Ж.Нарантунгалаг

Ж.Дөл

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн
Өмч хамгаалах байнгын зөвлөлийн
хурлын тэмдэглэл

2025 оны 08-р сарын 22-ны өдөр

Дугаар №07

Улаанбаатар хот

Хуралд өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга Ч.Энхболд, Гишүүд М.Солонго, А.Гэрэлт-Од, Б.Ганбаатар, Ж.Нарантунгалаг, Г.Мөнхтулга, Т.Мөнхтогтох, Ц.Золжаргал, Ж.Дөл, Э.Алтансүх, З.Арьяасүрэн, Э.Энхболд, нарийн бичгийн даргаар М.Оюунтунгалаг нарын бүрэлдэхүүнтэй 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 13.00 цагт Үндэсний оношлогооны төвийн 2 давхарын хурлын танхимд хуралдав.

Хурлыг нээж Ч.Энхболд: Өнөөдрийн өмч хамгаалах хурлыг нээж байна.

Хэлэлцэх асуудлуудыг танилцуулав. Үүнд:

Хэлэлцэх асуудал:

1. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний талаар
2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн актны талаар
3. Эмнэлгийн сул талбайг түрээслүүлэх талаар
4. Нүүлгэлттэй холбоотой зардал, төсвийн талаар
5. Номын сангийн байрны талаар
6. Өмч хамгаалах зөвлөлийн гишүүд солигдсон талаар

Хэлэлцсэн нь:

Нэгдүгээр асуудал:

Ч.Энхболд: Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний талаар ня-бо Ж.Нарантунгалаг танилцуулна гэв.

Ж.Нарантунгалаг: ТӨБЗГазрын “Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох тухай” 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 316-р тогтоолын дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой, 13 нэрийн, нийт 36,288,863.31 (гучин зургаан сая хоёр зуун наян найман мянга найман зуун жаран гурван төгрөг гучин нэгэн) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 17,881,897.50 (арван долоон сая найман зуун наян нэгэн мянга найман зуун ерэн долоон төгрөг тавин мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу санхүүгийн бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулж захирлын тушаал гаргана.

М.Оюунтунгалаг: Эрүүл мэндийн хөгжлийг төвөөс “Дуудлагын төв” болон “Зайн оношлогооны төв”-ийн үйл ажиллагааг Улсын хоёрдугаар төв эмнэлэгт шилжүүлэх болсонтой холбогдуулан хэрэглэж байсан тоног төхөөрөмж тавилга ТӨБЗГазрын 2025 оны 173-р тогтоолын дагуу балансаас балансад шилжиж ирсэн хөрөнгөнөөс элэгдэл дууссан хөрөнгөнүүдийг дахин үнэлсэн байгаа. Өмнө ирсэн дахин үнэлгээний тушаалын төсөл дээр нэмж эдгээр хөрөнгөнүүдийг оруулан дахин үнэлгээний тушаал нэг мөр гаргах саналтай байна.

Гишүүд санал нэгтгэйгээр ТӨБЗГазрын 295, 316-р тогтоолуудын дагуу эмнэлгийн захирлын тушаал гаргуулахаар санал нэгтэй зөвшөөрөв.

Хоёрдугаар асуудал:

Ч.Энхболд: Эмнэлгийн захирлын А/149 тоот тушаалын талаар ня-бо Ж.Нарантунгалаг танилцуулна гэв.

Ж.Нарантунгалаг: ТӨБЗГазрын 2025.06.27-ны өдрийн 304-р тогтоолын дагуу эмнэлгийн захирлын 2025 оны “Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тухай” А/149 дугаар тушаал гарсан. Энэ ажлын хэсгийг зөвлөлийн дарга Ч.Энхболд ахлаж байгаа. Нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй. Сүүлийн таван жил бараг эмнэлгийн тоног төхөөрөмж актлагдаагүй, няравын агуулахад ашиглагдахгүй, ажиллахгүй хөрөнгөнүүд маш их хураалттай байдаг. Энэ асуудал 2023 оноос хойш яригдсан. Дээд газраас материалын бүрдэл дутуу гэсний дагуу бүх зүйлийг бүрдүүлж тогтоол гарсан байгаа.

Ч.Энхболд: Үндсэн хөрөнгө актлах хэл амтай байдаг тул эмнэлгийн фейж групп дээр жагсаалтыг оруулах саналтай байна.

А.Гэрэлт- Од: Хөрөнгө актлах журмын дагуу акталж устгах саналтай байна, ажилчдад мэдэгдэх шаардлагагүй, тэгүүл өмч хамгаалах зөвлөл гэж байгаад хэрэггүй, бүх асуудлаа ажилчдын хурлаар авч хэлэлцэж байя.

М.Оюунтунгалаг: Тогтоол эмнэлгийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор акталж, устган данснаас хасах гэж гарсан байгаа. Нийтэд дэлгэж олон нийтэд цацах бодолгүй байна, сошиал хөгжсөн энэ үед хүмүүс татаж аваад цааш дэлгэрүүлэхийг үгүйсгэхгүй. Мөн акталсан хөрөнгийг энэ манайд хэрэгтэй гээд тасгууд буцаагаад өрөөндөө авч оруулах магадлалтай. Тогтоолын хэрэгжилтийг бид хэрэгжүүлж акталсан хөрөнгө энэ эмнэлэг дээр байхгүй акталж, устгасан гэсэн хариу биелэлт явуулдаг тул шууд акталж, устгах саналтай байна.

Э.Энхболд: Мэс заслын тасгаас шинэ тог баригч акталсан гэсэн гомдол гарсан. Энэ нь эмнэлгийн хэмжээнд 200 ш байдгаас тухайн тасаг болон бусад газарт ашиглагдаж байгаа 50 ш-ийг үлдээгээд бусдыг тооллогын комиссын санал оруулж ирсэний дагуу акталсан. Тасгийн нярав түүнийг сайн мэдэхгүй ашиглаж байгаа тог баригчийг хурааж авна гэсний дагуу гомдол санал гарсан байсан.

Ж.Нарантунгалаг: Хөрөнгө актлах хууль, журмын дагуу материалыг бүрдүүлж, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албанаас эвдрэл гэмтлийн талаар дүгнэлт гаргуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн газарт албан бичиг явуулан дүгнэлт гаргуулсан. Хэрхэн устгах талаар Төрийн өмчийн газраас зөвлөгөө авсан, тогтоол шууд акталж устгана гэж гарсан учир Хог ачилтын компанитай гэрээ байгуулан ажил үүргээ гүйцэтгэсэний дараа “ибаримт” шивүүлж хавсаргах хэрэгтэй гэсэн зөвлөмж өгсөн. Цацраг идэвхитэй эмнэлгийн тоног төхөөрөмж байвал зориулалтын компанид хандана гэсэн. Өмнө гарсан тогтоолын дагуу Хог ачилтын компанитай эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх гэрээ байгуулан акталж устгасан байгаа. Энэ аргаар акталж устган хогийн цэг дээр хаях саналтай байна гэв.

Гишүүд санал нэгтгэйгээр ТӨБЗГазрын 2025 оны 304, эмнэлгийн захирлын 2025 оны А/149 тоот тушаалын дагуу ажлын хэсэг жагсаалтад орсон хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор акталж устгахаар шийдвэрлэв.

Гуравдугаар асуудал:

Ч.Энхболд: Улсын хоёрдугаар төв эмнэлгийн сул талбайг түрээслүүлэх талаар танилцуулья.

1.Дэлгүүр ажиллуулах

2.Массажны сандал байршуулах

Эмнэлгийн ажилчид байгууллага дотроо “JS-25”, “Cu” гэх мэт сүлжээ дэлгүүрүүд ажиллуулах саналыг маш ихээр тавьж байгаа. Энэ саналын дагуу хүүхдийн эмнэлгийн 3 давхарт байрлаж буй шилэн өргөтгөлийг сайжруулж Garden маягаар дэлгүүр ажиллуулах санал оруулж байна.

М.Солонго: Дэлгүүр хэрэв ажиллуулахаар бол хоёр барилгыг холбосон хүзүүвчний төсөв дээд газарт явуулах, манайх цэвэрлэгээгээ хийчихвэл тухайн газар тохижилтоо хийгээд орох байх.

Ц.Мөнхтогтох: Тухайн шилэн фасадыг янзалж байсан компанид дахин янзлуулах талаар хүсэлт тавих саналтай байна.

М.Оюунтунгалаг: Тухайн сул талбайг ажлын хэсэг томилон хэмжилт хийж, халуун хүйтэн ус, тог цахилгааны асуудлыг шийдэж түрээслүүлж болох талаархи хүсэлтээ Төрийн өмчийн газарт явуулах саналтай байна.

Ч.Энхболд: Гарден дэлгүүр ажиллуулах талаар санал хураая. Нэг гишүүн түдгэлзсэн, 12 хүн зөвшөөрсөн байна.

Ч.Энхболд: 50 ортод байрладаг байсан дэлгүүрийн гэрээ 2024 оны 12 сард дуусгавар болсон. Тухайн барилга урсгал засварт орно гэсэн тул тухайн сул талбай дээр сонгон шалгаруулалт зарлаагүй. Засварын санхүүжилт энэ ондоо шийдэгдэгдэхгүй төлөвтэй байгаа тул өмнөх дэлгүүрийг ажиллуулах саналтай байна.

М.Оюунтунгалаг: Эмнэлгийн сул талбайг манай байгууллагын мэдлээр бусдад түрээслүүлж болохгүй тул хууль, журмын дагуу заавал Төрийн өмчийн газарт мэдэгдэж сонгон шалгаруулалт зарлан түрээслүүлэх хэрэгтэй. Түрээсийн журмын дагуу сонгон шалгаруулалтаа зарлан сонгогдсон байгууллагыг ажиллуулах байх саналтай байна. Хэрэв засвар хийхээр бол мөн л Төрийн өмчид албан тоот явуулж, түрээсийг авахгүйгээр түр түдгэлзүүлж болох байх. Төрийн өмчийн гэрээ дүгнэх шалгалт болон аудит ороход

түрээсийн байгууллагуудаар явж гэрээ болон бусад зүйлийг шалгадаг тул журмын дагуу л явуулах саналтай байна.

Ч.Энхболд: Энэ тал дээр санал хураая. Өмнөх дэлгүүрийг ажиллуулах саналтай зөвшөөрсөн хоёр, түдгэлзсэн нэг гишүүн, зөвшөөрөөгүй 10 хүн байна.

Ч.Энхболд: Эмнэлгийн ажилчдаас мөн массажны сандал байршуулах санал оруулсан байна. Мэс заслын тасагт 1 ш, мэдээгүйжүүлэлтийн хэсэгт 2 ш, оношлогооны 2 давхарт 1 ш, 1 давхарт 1 ш,

М.Оюунтунгалаг: Өмнө нь 6 ш сандал байдаг байсныг удирдлагаас эмнэлгийн орчинд тохирохгүй гээд Төрийн өмчид санал оруулан гэрээг цуцалсан. Ахин байршуулах бол мөн л Төрийн өмчид хүсэлтээ явуулан зөвшөөрөл авсаны дараа сонгон шалгаруулалтаа зарлан сандлыг байршуулах болов уу.

З.Арьяасүрэн: Эмнэлгийн орчинд түрээслэх газрын стандарт, сайдын тушаал байдаг эсэх харах хэрэгтэй. Би түдгэлзсэн саналтай байна.

Ж.Нарантунгалаг: Эмнэлгийн сул талбайг түрээслэх саналаа Төрийн өмчийн газарт явуулах саналтай байна.

Гишүүдийн олонхийн саналаар 50 орт барилгын 1 давхар, хүүхдийн эмнэлгийн шилэн фасад бүхий 3 давхар, массажны сандал байршуулах сул талбайг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт албан бичиг явуулан зөвшөөрөл авсаны дараа сонгон шалгаруулалт зарлахаар санал оруулав.

Дөрөвдүгээр асуудал:

Ч.Энхболд: Эрүүл мэндийн сайд наадмын өмнө ирж эмнэлгийн хашаанд баригдсан шинэ хоёр барилгыг манай эмнэлгийн эзэмшилд өгөх амлалт өгөөд явсан. Энэ дагуу захиргаа, санхүү зэрэг албадыг “Цахим-5” эмнэлэг рүү нүүлгэх талаар ярилцана гэв.

М.Солонго: Захиргааны ажилчид ихэнхи нь эмэгтэйчүүд, овор ихтэй шкаф, ширээ, сандлаа даахгүй байшингаас байшингийн хооронд лифтгүй, дээш 4 давхарт гаргахад хэцүү байгаа тул нүүлгэлтийн компани хөлсөлж оруулах саналтай байна.

Ц.Золжаргал: Шинээр баригдсан барилга руу нүүх гэж байгаа тул интернет оруулах сүлжээ татах шаардлагатай байгаа тул энэ зардлын талаар бас хэлэлцэх ёстой.

Э.Энхболд: Мэдээлэл технологийн албанаас нүүлгэлттэй холбоотой сүлжээ татахад шаардлагатай захиалгын хуудас бичсэн. Энэ дагуу шаардлагатай материалын жагсаалт гарган “Топика” ХХК, “Киберком” ХХК, “Вест компьютерс” ХХК-иудаас үнийн санал авсан. Эдгээр саналуудаас Киберком ХХК-ны үнэ хамгийн бага үнэтэй байгаа тул сонгох саналтай байна.

Гишүүд санал нэгтгэйгээр нүүлгэлттэй холбоотой зардал болон шууд худалдан авалтын гэрээ байгуулахыг удирдлагад уламжлахаар шийдвэрлэв.

Тавдугаар асуудал:

Ч.Энхболд: Номын сангийн байршил болон хариуцах эд хариуцагчийн талаар танилцуулна гэв.

М.Оюунтунгалаг: Номын фонд дансанд бүртгэлтэй нийт 1455 ш 22,7 сая төгрөгийн ном байдаг. Энэ оны хагас жилийн тооллогоор байрны асуудал шийдэгдээгүй тул тоолоогүй. Байршил болон эд хариуцагч тодорхойгүйгээс уг номнууд “Цахим-5” эмнэлгийн нэг өрөөнд тавиур болон номнууд хураалттай байгаа. 2024 оны хагас жилийн тооллогоор сувилахуйн сургуулийн оюутнуудын хүчээр номоо кодолж янзалж авсан, байхгүй 1 сая гаран төгрөгийн номыг захирлын тушаалаар акталсан. Энэ асуудлыг Өмч хамгаалах хурлаас Удирдлагын зөвлөлд уламжлах саналтай байна.

З.Арьяасүрэн: Уг ном нь том орон зай эзлэхгүй гэтэл Цогт-Очир захирлаас эмч, сувилагч, резидент, ажилчдад ном маш их хэрэгтэй гэсэн. Өмнө нь номын сан оношлогооны төвийн 1 давхарт удирдлагын зөвлөл хуралддаг өрөөнд байсан. Цаг бүртгэгч давхар номоо хариуцаад карте дээр номоо бүртгэсэн, бүртгэл үүсгээд ажилчдад үйлчилж гэртээ авч явж уншдаг байсан.

Ц.Мөнхтогтох: Явуулын номын сан ажиллуулж байгаа, манай эмнэлгийнхэн надад захиалгаа өгч авч уншдаг. Тухайн номын санг зөөж байхад хэрэгтэй номнууд их байсан.

Ч.Энхболд: Том номын сан ажилуулаад тэнд ажлын цагаар ном уншаад суух ажилчид байхгүй болов уу.

Гишүүд санал нэгтгэйгээр номын сангийн асуудлыг Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж цаашид хэрхэх талаар шийдвэрлэв.

Зургаадугаар асуудал:

Ч.Энхболд: Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүд солигдсон. Ц.Батмандах, Г.Батзаяа нар ажлаас гарсан, оронд нь түр хавсран гүйцэтгэгчээр М.Солонго, Б.Ганбаатар нар томилогдсон байгаа.

Гишүүд зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнтэй танилцав.



Шийдвэрлэсэн нь:

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 295, 316-р тогтоолуудын дагуу эмнэлгийн захирлын тушаал гарган дахин үнэлгээг журмын дагуу хийхийг нягтлан бодогч Ж.Нарантунгалаг,
 2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 304 дүгээр тогтоолын дагуу эмнэлгийн захирлын 2025 оны А/149 дүгээр тушаал гарсаныг яаралтай хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд нь дээд газарт явуулахыг нягтлан бодогч Ж.Нарантунгалаг,
 3. Эмнэлгийн сул талбайг түрээслэх асуудлыг Эдийн засгийн алба болон нягтлан бодогч М.Оюунтунгалаг,
 4. Нүүлгэлтийн зардал болон шууд худалдан авалтын гэрээг Эдийн засгийн алба болон ахлах нягтлан бодогч А.Гэрэлт-Од,
 5. Номын сангийн байршил болон эд хариуцагчийн талаар Удирдлагын зөвлөлийн хуралд санал оруулахыг зөвлөлийн дарга Ч.Энхболд нарт тус тус даалгав.
- Хурал 16 цагт тарав.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн

Дарга

Гишүүд:

	Ч.Энхболд
	М.Солонго
	А.Гэрэлт-Од
	З.Арьяасүрэн
	Ж.Нарантунгалаг
	Ж.Дөл
	Г.Мөнхтулга
	Ц.Золжаргал
	Б.Ганбаатар
	Ц.Мөнхтогтох
	Э.Алтансүх
	Э.Энхболд

Тэмдэглэл хөтөлсөн: Байнгын зөвлөлийн нарийн бичгийн дарга

М.Оюунтунгалаг

